

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД, ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
НАРЫН 2021 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2021.12.13

Д/д	Хэрэгжүүлэх ажиллагаа	үйл	Санхүүжилтийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Хувь
МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР								
1	Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах	Төсөл-60,0 сая ОНХС-350,0 сая	Өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангасан хувь	2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг 70 хувиар хангасан.	2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг 80 -аас багагүй хувиар хангасан байна.	2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, Аймгийн Засаг даргын 03 тоот албан даалгавар, ХХААГ-ын даргын зөвлөмжийг сумдад хүргүүлэн ажиллаж төлөвлөгөөний хэрэгжилт 80,8 хувьтай.	100	
2	Малын тоо толгойн албан татварын хэмжээг, малын төрөл тус бүрээр тогтоох ажлыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	0		Ажил хийгдээгүй	Аймаг сумын ЗДТГ-ын хөдөө аж ахуйн асуудал хариуцсан нэгж малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтооход шаардлагатай судалгаа мэдээллийг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлж, тогтоол гаргуулсан байна.	Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6.1 дэх заалт буюу нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээг 0-2000 төгрөг байхаар хуульчилсны дагуу сум бүр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа нэг малаас авах татварын хэмжээг батлан 7 дугаар сарын 01-ний өдрөөс малын хөлийн татварыг авч байна. Хүнс, хөдөө аж ахуйн газраас Өндөршил омгийн адуу, Хулдын Олдохын хүрэн бор омгийн тэмээг өсгөн үржүүлэх зорилгоор ашиглаж байгаа тул малын хөлийн албан татвараас чөлөөлүүлэх саналыг дээрхи 2 сумын Иргэдийн Төлөөлөгчдийн	100	

						Хуралд хүргүүлснээр малын хөлийн татвараас чөлөөлсөн шийдвэрийг гаргууллаа.	
3	Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх	УТ-200,0 сая	Техникийн үрдүн 80-аас дээш хувьтай тэмцсэн байна.	Улсын төсвийн хөрөнгөөр 100 мянган га талбайд үлийн цагаан оготнотой тэмцэх ажил зохион байгуулсан	Бэлчээр хамгаалах тухай Засгийн газрын 185 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдсан байна.	ХХААХҮЯмны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Мөнхнасан сумдын удирдлага, холбогдох мэргэжилтнүүдэд арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7 сумын 20,0 мянган га бэлчээрийн талбайг чөлөөлүүлж, бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой микробиологийн, 7 сумын 50,0 га талбайд энгийн механик аргаар тус тус тэмцэх ажлыг гүйцэтгэж үр дүн 81,8 хувьтай байна.	100
4	Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах		Таваарын малын 30-аас доошгүй хувийг эдийн засгийн эргэлтэд оруулсан.	Таваарын малын 10-иас доошгүй хувийг болон ангилалтаар үржилд тэнцээгүй малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан байна.	Таваарын малын 10-иас доошгүй хувийг болон ангилалтаар үржилд тэнцээгүй малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан байна.	Таваарын болон үржилд тэнцээгүй 748500 малаас 249300 малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан бөгөөд 33,3 хувийг хэрэгцээлээд байна. Өвөл хаврын улиралд орон нутгийн хүн амын махны хэрэгцээг хангах зорилгоор хонь-108тн, ямаа-44.5 тн мах буюу 152,5 махыг зориулалтын хөргүүртэй агуулахад нөөцөлсөн бол Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээг хангах махны өргөтгөсөн худалдаагаар малчид	70

						бэлтгэсэн махаа борлуулах боломжийг олгосноор өнөөгийн байдлаар 162,1 тн махыг нийлүүлсэн. Цаашид зах зээлд нийлүүлсэн махны хэмжээ болон нөөцийн махны хэмжээ нэмэгдэнэ.	
5	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах	Төсөл хөтөлбөр ОНТ 230,0 сая	Гаргасан худгийн тоо	Бэлчээрийн усан хангамжийн зориулалттай 60 худаг шинээр барьж ашиглалтад оруулсан.	Бэлчээрийн усан хангамжийн зориулалттай инженерийн хийцтэй худаг 10-аас доошгүй тоогоор нэмэгдсэн байна.	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил, Шинэ хөдөө төсөл, ОНХС, малчдын хөрөнгө оруулалтаар 6 суманд 12 инженерийн хийцтэй гүн өрмийн худаг, 2 суманд 16 цооног, 5 суманд нийт 44 энгийн уурхайн худгийг сэргээн засварлан нийт 83000 га бэлчээрийг усжуулж, өмнөх оноос бэлчээр усжуулалт 0,3 хувиар нэмэгдсэн.	100
6	Монгол малчин үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Малчдад зориулсан соён гэгээрүүлэх аян” ыг зохион байгуулж хэрэгжүүлэх	УТ- 1 сая Төсөл хөтөлбөр- 24,0 сая	Соён гэгээрлийн аян зохион байгуулсан байна	Боловсруулж байгаагүй	Монгол малчин үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Малчдад зориулсан соён гэгээрүүлэх аян” ыг зохион байгуулж эхлүүлсэн байна.	“Малчдад зориулсан соён гэгээрүүлэх аян”-ы хүрээнд 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр байгууллагын үйл ажиллагаагааг сурталчлах “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Цагаандэлгэр суманд зохион байгуулж өдөрлөгт 14 сумын 73 өрхийн 142 иргэн оролцлоо. Нээлттэй хаалганы өдөрлөгөөр иргэдэд мэдээ мэдээлэл, төрийн зарим үйлчилгээг хүргэснээс гадна Цагаандэлгэр сумын Дэлгэрэх зам багийг жишиг болгон "Мал бүртгэлжүүлэлтийн аян"-ыг	100

						эхлүүлж нийт 770 бод, 15175 бог малын хээлтэгчийг 100 хувь ялган тэмдэглэж, бүртгэлжүүлжээ.	
7	Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг, ангилалт явуулж стандартын шаардлага хангасан цөм сүргийг бүрдүүлэх, баталгаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах;	УТ- 34,0 сая	Ангиласан малын тоо	20000 малыг үзлэг ангилалтад хамруулсан.	22000 малыг үзлэг ангилалтад хамруулсан байна.	Энэ онд улсын төсвөөр хийгддэг мал ангилалтын зардал хасагдаж ирснээс шалтгаалан 16800 малыг үзлэг ангилалтанд хамруулсан. Төрлөөр авч үзвэл: Баянжаргалан сумын 800 үхэр, Хулдын Олдохын хүрэн бор омгийн 4000 тэмээ, Сайнцагаан омгийн 4000 хонь, Өндөршилд омгийн 4000 адуу, Эрдэнэдалай сумын Ширгийн говийн нутгийн монгол 4000 хонинд хавар, намрын ангилалтыг технологит хугацаанд хийлээ.	70
8	Бог малын хээлтүүлэгчийг Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтанд шилжүүлж ялган төвлөрүүлэх;	0	Ялган суурилсан хээлтүүлэгч мал хувиар	1200 хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлсэн.	Үржилд ашиглаж буй нийт хуц, ухнын 15%-ийг ялган төвлөрүүлсэн байна.	2020 онд хаваржилт хүндэрсний улмаас хээлтүүлэгч малын 11,7 хувь буюу 2230 хээлтүүлэгч хорогдсон. Ялган суурилсан хээлтүүлэгч хуц 2427, ухна 1701 бүгд 4128 хээлтүүлэгч мал ялган суурилсан нь нийт хээлтүүлэгч малын 23,8 % -ийг эзэлж байна.	100
9	Баталгаажсан үүлдэр, омгийн малын үрийг авах, генийн санг хамгаалах,	ОНТ-5,0 сая	Авсан үр тун	Ажил хийгдэж байгаагүй	Нутгийн шилмэл 50-иас доошгүй малд өндөр ашиг шимт малын үрээр зохиомол	Сайнцагаан сумын Далай багийн 3 өрхийн 400 хонинд мах-ноос-өөхний чиглэлийн Сайнцагаан омгийн хуц болон түргэн өсөлттөй махны чиглэлийн суффлок үүлдрийн	100

	биотехнологийн ололтыг нэвтрүүлэх				хээлтүүлэг хийсэн байна.	хуцны үр, нутгийн монгол үхэрт өндөр ашиг шимт Сэлэнгэ үүлдрийн гүн хөлдөөсөн үрээр 17 үхэрт тус тус зохиомол хээлтүүлэг хийсэн. Мөн малын удмын сангийн үндэсний төвд Сайнцагаан омгийн 3, нутгийн монгол 3 хуцнаас 1236 тун үрийг авч хадгалуулаад байна.	
10	Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж байгуулах, дэмжиж ажиллах;	УТ- 34,0 сая, Хувь хөрөнгө- 10,0 сая	Шинээр байгуулагдсан аж ахуй нэгжийн тоо	Аймгийн хэмжээнд 3 нэгжтэй, 2020 онд 3 нэгжтэй гэрээ байгуулж ажилласан.	Нэгжийн үйл ажиллагааг бүрэн дэмжиж, 1 нэгж шинээр байгуулсан байна.	Мал зүйч үржүүлэгчдийн холбоо, Уудам жаргалант, Хулд таван эрдэнэ ХХК-иудын үзлэг ангилалтын үйл ажиллагаанд 40,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний “Уул хадарганатай” ХХК шинээр байгуулагдан үйл ажиллагаа нь жигдэрсэн ба улмаар сүүний чиглэлийн ямааны фермер хөгжүүлэхээр хүсэлтээ ирүүлснийг дэмжиж албан тоот хүргүүлсэн.	100
11	Үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгчийг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;	Хувийн хөрөнгө- 5,0 сая	Ялган тэмдэглэж бүртгэл мэдээллийн санд хамрагдсан малын тоо	Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 21000 мянган мал бүртгэгдсэн байна.	Өмнөх оны хүрсэн түвшинг 20 хувиар нэмэгдүүлсэн байна.	Үржлийн малыг ээмэглэх ажлын хүрээнд 1000 тэмээ, 2000 хонь, 100 адуу, Баянжаргалан сумын цөм сүргийн 200 үхэр, нутгийн монгол 1000 хонь нийт 4300 ээмэглэж ялган тэмдэглэж өмнөх оны түвшингээс 20,6 %-иар нэмэгдүүлсэн. ХХААХҮЯам нь малын бүртгэл	100

						мэдээллийн нэгдсэн сангийн программыг шинэчлэн боловсруулж байгаа тул ээмэгжүүлсэн малыг бүртгэлд оруулах ажил хүлээгдэж байгаа болно.	
12	Орон нутгийн тусгай хэрэгцээний сумын болон сум дундын отрын бүс нутаг байгуулах	ОНТ-1,0 сая		Судалгааны ажил хийгдсэн	Орон нутгийн тусгай хэрэгцээнд авч хил заагийг тодорхойлон газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд оруулсан талбайн хэмжээ нэмэгдсэн байна.	Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Өлзийт сумдын сум дундын отрын бүс нутгаар 74,3 мянган га бэлчээрийн талбайн координатыг тогтоож Засаг даргын дэргэдэх зөвлөлийн болон Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулан дэмжигдсэн. Эцсийн шийдвэрийг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдийн VII хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлээ.	100
13	Махны чиглэлийн хонины аж ахуйн эрчимжүүлэлтийг дэмжих	Хувийн хөрөнгө-10,0 сая		Махны болон бордож байгаа хонь байхгүй	2-с доошгүй аж ахуйд 1000 доошгүй толгой хоньтой бордооны аж ахуйтай болсон байх	Сайнцагаан суманд махны чиглэлийн суффлок үүлдрийн сайжруулагч ашиглан 1000 хонины хагас эрчимжсэн аж ахуй хөгжүүлэхээр 1, Цагаандэлгэр, Говь-Угтаал суманд керей үүлдрийн сайжруулагч ашиглан 1200 хонины хагас эрчимжсэн аж ахуй хөгжүүлэхээр 2 иргэн тус тус үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.	100
14	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг	0	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө	Сум бүр бэлчээрийн менежментийн	Сум бүр бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж жилийн	70

	шинэчлэн боловсруулж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан, хэрэгжилтийг хангах		хэрэгжилтийн хувь	боловсруулж хэрэгжүүлсэн.	төлөвлөгөөг шинэчлэн баталж хэрэгжүүлсэн байна.	эцсийн байдлаар сумдын төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 80,1 хувьтай байна.	
15	Сум тус бүрээр сүргийн эргэлтийн тооцоо гаргаж, бэлчээрийн даацаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах	Хувь хөрөнгө-10,0 сая	Эдийн засгийн эргэлтэд оруулсан малын тоо.	Нийт мал сүргийн 0,36 хувь буюу 249.6 мянган толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулж 5174.6 тн мах бэлтгэсэн.	Хэрэгцээний малын 10-аас доошгүй хувь, үзлэг ангилалтаар үржлийн шаардлага хангаагүй малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан байна.	Таваарын болон үржилд тэнцээгүй нийт мал буюу 748500 малаас 249300 малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан бөгөөд хэрэгцээний сүргийн 33,3 хувийг хэрэгцээлээд байна.	100
16	Орон нутагт өсгөх мал сүрэг, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөлт, тоо толгойн өөрчлөлтийг тооцох, хэрэгжилтийг зохион байгуулах	0	Стратеги төлөвлөгөө боловсруулсан байна	Малын төрөл тус бүрээр үржил селекцийн ажилд баримтлах зарчим, чиглэлийг тодорхойлсон Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги /2020-2030/ батлагдаж, бүх шатны мэргэжлийн байгууллагад хүргэгдсэн.	Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги /2020-2030/-ийн дагуу мал сүргийн эргэлт, төлөвлөлтийг тооцсон байна.	ХХААХҮЯ-аас батлан хэрэгжүүлж буй “2020-2030 оны үржлийн ажил”-ын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/45, А/491, 2020 оны А/358 тоот тушаалаар омгоор баталгаажсан Өндөршил адуу, Сайнцагаан хонь, Олдохын хүрэн бор тэмээний үржлийн ажлын төлөвлөгөөг 5 жилээр батлуулан хэрэгжүүлж байна. Таван төрлийн малын сүргийн эргэлтийг хийж малын сүрэгт эзлэх хувийг тооцоход тэмээ	100

[illegible]

19	2021 оны тариалалтын төлөвлөгөөгөөр өгч байгаа даалгаврын дагуу таримал тус бүрийн тариалах талбайг бууруулахгүйгээр тариалах, зорилтот ургацыг хураан авах ажлыг зохион байгуулах. (Тариалалт, ургацын төлөвлөгөөг хавсаргав)	ОНТ – 0 УТ – 2,3 сая Хувийн хэвшил – 50,0 сая	Төмс, хүнсний ногоог тариалах хэмжээ /га/ Төмс, хүнсний ногоо хураан авах ургацын хэмжээ /тн/	2020 оны ургацын дүн		Аймгийн хэмжээнд 18 ААН, 136 иргэн төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээлийн ургамал 66,3 га талбайд тариалж 419,2 тн-ийг хураасан нь өмнөх оноос 32 тн-оор нэмэгджээ. Өвөл зуны хүлэмжийн 12700м ² талбайд тариалалт хийж талбайн хэмжээг өмнөх оноос 1200 м ² талбайгаар нэмэгдэж 56,6 тн ургац хураан авсан бол малын тэжээлийн ургамал, ногоон тэжээл 16,1 талбайд тариалалт хийж 21,2 тн малын тэжээл хураан аваад байна.	70
20	10-аас дээш жилийн насжилттай, шинэчлэвэл зохих техникийн судалгааг сум, иргэн аж ахуйн нэгжээр, техникийн төрөл, маркаар гаргаж ирүүлэх.	0	Судалгааг ХХААХҮЯамын ГТБХЗГазарт хүрүүлсэн байна.	Техникийн судалгааг ашиглалтын хугацаатайгаар нарийвчлан гаргаагүй.	10-аас дээш жилийн насжилттай, шинэчлэвэл зохих техникийн судалгааг сум, иргэн аж ахуйн нэгжээр гаргаж, хөрөнгө оруулалтын тооцоог, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тооцоотой уялдуулах боломж бүрдүүлнэ.	Техник, тоног төхөөрөмжийн 10-аас дээш жилийн насжилттай 25 морины хүчин чадалтай 10 тракторын бэлэн байдлын судалгааг гарган хүргүүллээ. Шинэ хөдөө төслийн 74,9 сая төгрөгийн санхүүжилтээр газар тариалангийн хөрс боловсруулалтын зориулалттай бага оврын болон 80 морины хүчин чадалтай тракторыг Сайнцагаан, Баянжаргалан суманд дагалдах иж бүрдэлтэй нийлүүлэн орон нутгийн өмчийн бүртгэлд бүртгэлжүүлээ.	100

21	Хөдөө аж ахуйг дэмжих сангаас авсан техник тоног төхөөрөмжийн өр авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх	Хувийн хэвшил – 2,26 сая	10 иргэний	Ажил удаашралтай байна.	Хөдөө аж ахуйг дэмжих сангаас авсан техник тоног төхөөрөмжийн өр авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлж, дэмжлэг авах боломжийг нэмэгдүүлсэн байна.	Урьд оны эцэст өрийн үлдэгдэл 5,153,862 төгрөг төлөхөөс 2,269770 төгрөг төлсөн буюу энэ онд гэрээний дагуу төлөгдөх төлбөрийг 100 хувь төвлөрүүлсэн.	100
22	Аймгийн санаачлага, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1000 м ² талбайтай өвлийн хүлэмж байгуулж тариалалт хийх	ОНТ – 50,0 сая Хувийн хэвшил – 7,6 сая	Сайнцагаан суманд байгуулагдсан "Өвлийн нарлаг хүлэмж"-ийг 1200м ² тариалсан байна. Хураан авсан ургац тн-оор	Татварын хуулинд орон нутгийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтын боломжийг өргөжүүлсэн.	Өвлийн хүлэмж байгуулж тариалалт эхлүүлсэн байна.	ОНХС-ийн 50,0 сая төгрөгийн хөрөнгөөр өвлийн нарлаг хүлэмжийн гадна цэвэр усны шугамын ажил хийгдэж 1200м ² талбайгаас 16,9 тн ургац хураан авсан байна. Мөн “Шинэ хөдөө” төслөөс 73,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дуслын усалгааны систем бүхий 32 ширхэг зуны хүлэмжийг нийлүүлж сумдад хүлээлгэн өглөө.	100
23	Өөрийн орон нутагт жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх, жимсний палантаци байгуулахыг дэмжиж ажиллах	ОНТ – 20,0 сая	Шинээр тариалагдсан талбайн хэмжээ- /га/ Хураан авсан ургац - /тн/	Татварын хуулинд орон нутгийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтын боломжийг өргөжүүлсэн.	Жимсний тариалалт, ургацын хэмжээг өмнөх оноос нэмэгдүүлсэн байна.	Жимс жимсгэний тариалалтын талбай 6,4 га-аар нэмэгдснээр талбайн хэмжээ 65,6 га болсон хэдий ч 2.7 тн ургац хураан авсан нь өмнөх оноос ургац 1,5 тн-оор буурсан. “Эх дэлхийгээ аваръя жиргээ холбоо” ТББ-тай хамтран “Дундговно ногооруулъя” модны экологи, эдийн засгийн үнэ цэнийг иргэдэд ойлгуулан, экологийн	70

						боловсролыг дээшлүүлэх сургалтанд нийт 78 тариалан эрхлэгчийг хамрууллаа. Сургалтад хамрагдсан тариаланчид нь сум орон нутагтаа газар тариалан, ногоон байгууламжийг хөгжүүлэх, сургалтаар олж авсан мэдлэг, туршлагыг бусдад түгээх үүрэгтэйгээр бэлтгэгдсэн.	
24	Газар тариалангийн салбарын мэдээ тайланг өгөгдсөн маягтын дагуу цаг хугацаанд нь ирүүлж, тариалангийн үйлдвэрлэлийг шуурхай зохион байгуулж ажиллах	ОНТ	мэдээний тоо	Мэдээ тайлангийн эх сурвалжийг баталгаажуулах ажил дутагдалтай.	Мэдээ тайлангийн эх сурвалжийг баталгаажуулж, тайлан мэдээг маягтын дагуу хугацаанд нь ирүүлсэн байна.	Тариалалтын бэлтгэл болон салбарын холбогдолтой бусад мэдээллийг тайлант хугацаанд нь давхардсан тоогоор 35 удаа хүргүүллээ.	100
25	Зоорь, агуулах, элеваторыг паспортжуулж бүртгэлжүүлэх ажлыг Барилгын тухай хуульд заасны дагуу үргэлжлүүлж хийх	ОНТ – 36,0 сая ЗЗББУТ – 84,0 сая СХС – 30,0 сая Хувийн хэвшил – 50,0 сая	Зоорийн судалгааг холбогдох газарт 1 удаа хүргүүлсэн байна.	Ажлын эхлэл амжилттай байна.	Зоорь, агуулах, элеваторын чанар, хийцийг тодорхойлж, нэгдсэн дэлгэрэнгүй бүртгэлтэй болсон байна.	Зоорийг бүртгэлжүүлэх ажлын хүрээнд нийт 12 сумын 470 тонны багтаамжтай 23 ш зоорийн дэлгэрэнгүй судалгааг нэгтгэн хүргүүллээ. Зоорийн чанар хийцийг дүгнэхэд 23% нь сайн, 77% нь элэгдэж муудсан байв. ЗЗББУХТөсөл, ОНХС-ийн 120,0 сая төгрөгийн өртөг бүхий 50тн-ы багтаамжтай хүнсний зоорийг нийлүүллээ. Тухайн зоорь нь ангилан ялгах болон хадгалах зориулалттай 2 тасалгаанаас бүрдсэн болно.	100

26	Төмсний үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх аймгийнхаа хэрэгцээг хангах, мэдээ тайланг бүрэн, үнэн зөв авч хугацаанд нь тайлагнах	Хувийн хэвшил – 30,0 сая	Талбайн хэмжээ / га / Хураан авсан авсан ургац тн	2020 оны тариалалт ургац хураалтыг хүснэгтээр хавсаргав.	Төмсний үйлдвэрлэлийн зорилт, хүрэх үр дүнг хавсаргав.	28 га-аас 233 тн төмс хураан авч аймгийн жишсэн дундаж хүн амын хэрэгцээний 14,5 хувийг хангаснаар өмнөх оноос төмсний хангамж 0,9 хувиар өссөн.	100
27	Хүнсний ногоо хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, тогтвортой хөгжүүлэх аймгийнхаа хэрэгцээг 2020 оны түвшингээс 5-10 хувиар нэмэгдүүлэх, мэдээ тайланг бүрэн, үнэн зөв авч хугацаанд нь тайлагнах	Хувийн хэвшил – 20,0 сая	Талбайн хэмжээ / га / Хураан авсан авсан ургац тн	2020 оны тариалалт ургац хураалтыг хүснэгтээр хавсаргав.	Хүнсний ногооны үйлдвэрлэлийн зорилт, хүрэх үр дүнг хавсаргав.	19,5 га-аас 162,3 тн хураан авч аймгийн жишсэн дундаж хүн амын хэрэгцээт хүнсний ногооны 4,5 хувийг хангаж өмнөх оноос хангамж 0,8 хувиар нэмэгдсэн байна.	100
28	Газар тариалан эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдэд хөдөө аж ахуйн зохистой дадал, эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлэх	0	Цахим хэлбэрээр 20 тариалан эрхлэгчдэд хүргэн ажилласан.	Газар тариалангийн зохистой дадал эзэмших ажил эхлэлийн шатанд байна.	Ургамал хамгааллын цогц арга хэмжээг нэвтрүүлэх, бордоо, ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээний чиглэлээр мэргэжлийн байгууллагуудта	Хөдөө аж ахуйн зохистой дадал, эзэмшүүлэх, ургамал хамгааллын мэдлэг олгох сургалтад 30 тариалан эрхлэгч хамруулж, ХАА-н зохистой дадал (GAP) нэвтрүүлэх Монгол улсын үндэсний стандартын мэдлэгийг олголоо. Мөн хүнсний нарийн ногоогоор орон нутгийн зах зээлийг хангах оновчтой шийдэл, стратегийг тодорхойлох зорилготой	100

					й хамтран сургалт, семинар зохион байгуулсан байна.	“Хамтдаа шийдье” хэлэлцүүлгийг АЗДТГ, ХХҮГ, Дэлхийн банк, Монголын тариаланчдын үндэсний холбоо, Говийн шимт ургац ТББ-тай хамтран зохион байгуулж, 114 хүнийг хамрууллаа. Хэлэлцүүлгийн үр дүнд орон нутагт хүнсний ногоо тариалах оновчтой стратеги, 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх талуудын оролцоог тодорхойллоо.	
29	Тариалангийн талбайн хөрсийг шинжилгээнд хамруулах, шинжилгээний дүнгийн нэгтгэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг ирүүлэх	Хувийн хэвшил – 80,0 мянган төгрөг	Шинжилгээний хамрагдсан иргэдийн тоо, талбай хэмжээ –га-аар	Тариалангийн талбайн хөрсийг шинжилгээнд хамруулах ажил хангалтгүй хийгдсэн.	Тариалангийн талбайн хөрсийг шинжилгээнд хамруулах, шинжилгээний дүнгийн нэгтгэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг ирүүлсэн байна.	Тариалангийн талбайн хөрсний шинжилгээнд Адаацаг, Дэлгэрцогт сумдын 2 иргэний нийт 30 га талбайн 4 дээжийг ХААИС-ийн хөрс судлалын лабораторит шинжлүүлснээр талбайн хөрсний үржил шим сайжрах, цөлжилт буурах, нэгжээс авах ургацын хэмжээг нэмэгдүүлэхэд үр дүнгээ өгсөн ажил боллоо.	100
30	Тариалангийн талбайг хашаажуулах, хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулах	ОНТ – 10,0 сая төгрөг		Орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалт гаргах ажил хангалтгүй байна.	Тариалангийн талбайг хашаажуулах, хамгаалалтын ойн зурвас байгуулах ажилд орон нутгийн төсвөөс хөрөнгө гаргаж тодорхой ажил хийсэн байна.	Орон нутгийн хөгжлийн сангийн 10 сая төгрөгийн хөрөнгөөр Эрдэнэдалай, Дэрэн, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Гурвансайхан сумдад 5 га талбайд ойн зурвас шинээр байгуулж 3000 ширхэг улиас, хайлаас, агч мод бут, Сайнцагаан, Сайхан-Овоо, Хулд сумдын нийт 50,7 га ойн	100

						зурвасд мод бут тус тус тариалсан байна.	
31	Услалтын системийг бүртгэлжүүлж, паспортжуулах	Шинэ хөдөө төсөл – 42,4 сая	0	Бүртгэлжүүлэх ажил хангалтгүй	Услалтын системийг бүртгэлжүүлж тайлан мэдээг хугацаанд нь ирүүлсэн байна.	Шинэ хөдөө төслийн 53,4 сая төгрөгийн хөрөнгөөр дуслын усалгааны систем 2, намираа усалгааны хоолой 20, усны нөөцийн сав 8 ширхэгийг тус тус нийлүүлж бүртгэлжүүллээ.	100
Хүнсний салбарын чиглэлээр							
32	Аймаг, сумын хүнсний тэнцлийг тооцож хэвших	0		Хүнсний тэнцлийг тооцож хэвшээгүй	Хүнсний тэнцлээ тооцож, хүнсний баталгаат байдлыг бүрдүүлэх бодлого арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэн, тайлагнасан байна.	Аймаг сумын хүн амын жишсэн дундаж хүн амыг тооцож, сум тус бүрийн хүн амын гол нэрийн бүтээгдэхүүний жилийн хүнсний хэрэгцээг тооцоолон 7 хоног бүр гол нэрийн 12 төрлийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгааг ХХААХҮЯ-нд хүргүүллээ. Орон нутгийн үйлдвэрлэлээр хүнсний тэнцлийг тооцоход гурилан бүтээгдэхүүний нийлүүлэлт 4,3%, мах, махан бүтээгдэхүүн 0,59%-тай байна.	100
33	Махны нөөц бүрдүүлэх, өвлийн идэш зэрэг нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах	Хувийн хэвшил – 500,0 сая		Махны нөөцийг жил бүр тогтмол бүрдүүлэхгүй байна.	Хүн амын хаврын улирлын хэрэгцээний 30 хүртэлх хувийг хангах мах нөөцөлж, нийлүүлсэн байна.	Өвөл хаврын улиралд орон нутгийн хүн амын махны хэрэгцээг хангах зорилгоор хонь-108тн, ямаа-44.5 тн мах буюу 152,5 махыг зориулалтын хөргүүртэй агуулахад нөөцөлсөн бол Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээг хангах махны өргөтгөсөн худалдаанд 162,1 тн махыг нийлүүлжээ. Цаашид нөөцийн хэмжээ нэмэгдэнэ.	70

34	Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах	УТ – 1,610.0 сая төгрөг		Мал нядлах, мах боловсруулах үйлдвэрийн технологи, зохистой дадлын хэрэгжилт шаардлага хангадаггүй.	Мах, махан бүтээгдэхүүн экспортлох чадавхийг бүрдүүлсэн байна.	Малын арьс ширний үнэ цэнийг нэмэгдүүлэх, малыг үйлдвэрлэлийн орчинд төхөөрч, хүнсний эрүүл ахуйн аюулгүй байдлыг сайжруулах боломжийг бүрдүүлэхээр НҮБ- ын Аж үйлдвэр, хөгжлийн байгууллагын дэмжлэгтэйгээр малын арьс шир өвчиж, хуулах SFF төхөөрөмжийг “Шувуутайн оргил” мах төхөөрөх цехэд суурилууллаа. БНХАУ-руу 14,000 толгой бүхий 252 тн махыг экспортлоход бэлтгэн өгсөн.	100
35	“Эрүүл хүнс-эрүүл монгол хүн”, “Сав баглаа боодол”, үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх	Хувийн хэвшил 7,5 сая Говийн зэрэглээ төсөл – 7,5 сая		Хөтөлбөрүүдийн хэрэгжилт 30-70 хувийн хэрэгжилттэй байна.	Хөтөлбөрийн хэрэгжилтийг өмнөх оноос 30 хүртэл хувиар ахиулсан байна.	“Эрүүл хүнс- Эрүүл монгол хүн”, “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 10 арга хэмжээг төлөвлөн 100 хувь хэрэгжүүлснээр хэрэгжилтийн хувь өмнөх оноос 30 хувиар өссөн байна.	100
36	Согтууруулах ундаа түүгээр үйлчлэх цэгийн тоог бууруулж, ХХААХҮ- ийн сайдын 2020 оны А/277 дугаар тушаалыг хэрэгжүүлэх	Хувийн хэвшил – 9,8 сая		ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 277 дугаар тушаал гарсан.	Согтууруулах ундаа түүгээр үйлчлэх цэгийн тоог өмнөх оноос 10 хувь хүртэл бууруулсан байна.	2020 оны ХХААХҮС-ын А/277 дугаар “Норматив тогтоох тухай” тушаалаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог аймаг, нийслэл, суманд 1000 хүн ам тутамд 4 хүртэл байхаар тогтоосон. 2021 онд тусгай зөвшөөрлийн эрхийг сунгуулахаар 18, шинээр авахаар 17 аж ахуйн нэгж байгууллага саналаа ирүүлснээс 32 зөвшөөрлийг /шинээр 12, сунгасан 18,	70

						сэргээсэн 1, хүчингүй болгосон 5/ хэлэлцэн шийдвэрлэлээ. Нийт тусгай зөвшөөрлийн тоо 130 болж өмнөх оноос 9-өөр нэмэгдсэн. Энэ нь шинээр байгуулагдсан стандартын шаардлагад нийцсэн худалдаа үйлчилгээний байгууллага байгаа болно. Цаашид стандартын шаардлагад нийцээгүй болон холбогдох хуулийн зөрчил гаргасан худалдаа үйлчилгээний газрын тусгай зөвшөөрлийн эрхийг хүчингүй болгож тоог цөөрүүлэхээр зорьж байна.	
37	Түүхий сүүний нийлүүлэлтийг сэрүүний улиралд нэмэгдүүлэх	0		Урамшуулалд хамрагдах нөхцөл бүрдээгүй	Урамшуулалд хамрагдаж, сүүний нийлүүлэлт 20 хүртэлх хувиар нэмэгдсэн байна.	Манай аймгийн хувьд отор нүүдэл ихтэй газрын гарц муу байснаас шалтгаалан энэ жил төл бойжилтоос шалтгаалан сүүний нийлүүлэлт хийгдээгүй.	0
38	Хүнсний ногооны хангамж, нийлүүлэлтийг тогтворжуулах	Хувийн хэвшил – 20,0 сая		Хүн амын хэрэгцээг эх орны хөрсөнд ургасан хүнсний ногоогоор хангах стратеги төлөвлөгөө байхгүй	Хүн амын хэрэгцээг эх орны хөрсөнд ургасан хүнсний ногоогоор хангах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллах	Аймгийн хэмжээнд 47,5 га-аас 395,3 тн төмс, хүнсний ногоо хураан авч жишсэн дундаж хүн амын хэрэгцээний 18,8 хувийг хангасан. Хангамж өмнөх оноос 1,6 хувиар нэмэгдсэн. Хүнсний ногоо дэд хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилт 100%	100
39	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай	0		Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-аас 2021-2025 онд Дундговь аймагт “Ерөнхий боловсролын сургуулийн	100

	хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах			хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.	тухай хуулийн хэрэгжилтийг хангаж хуульд заасан Засаг даргын үүргийг хэрэгжүүлж, тодорхой ажил хийж, үр дүнд хүрсэн байна.	үдийн хоолны үйлдвэрлэлийг дэмжих төсөл"-ийг хэрэгжүүлэхээр боллоо. Төслийн 1-р үе шатанд үдийн хоолны хөтөлбөрийн өнөөгийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, сургуулийн хоол зүйчдийг бэлтгэх, сурагчдын үдийн хоолны шим тэжээлийн стандартыг сайжруулан, хоолны цэсийг баяжуулах төлөвлөгөөг боловсруулах, 2-р үе шатанд судалгааны үр дүнд суурилан сурагчдын онцлогт тохирсон шим тэжээлтэй хоол хүнсийг нийлүүлж эхлүүлэх зэрэг ажлууд хийгдэнэ.	
40	Монгол Улсын худалдааны салбар үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ойн арга хэмжээг угтсан бүтээлч ажлыг тодорхой төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэх	0		Худалдааны салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлсэн.	3-аас доошгүй бүтээлч ажил төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.	Худалдааны салбарын 100 жилийн ойг угтан худалдааны байгууллагын 40 гаруй ажилтанд стандартын мэдлэг олгох сургалт, 22 ААН байгууллагын худалдагч оролцсон мэдлэг ур чадварын уралдаан, худалдааны байгууллага, ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн дунд гар бөмбөгийн тэмцээнийг тус тус зохион байгуулсан ба худалдааны байгууллагад амжилттай ажиллаж байгаа 120 гаруй хүнийг 100 жилийн ойн медаль, 20 гаруй хүнийг салбарын шагналд тодорхойлон шийдвэрлүүллээ.	70

						Худалдааны 100 жил, Ахуйн үйлчилгээний салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн баярын хурлын арга хэмжээг зохион байгуулж Төрийн болон салбарын шагнал, ойн медалуудаар 50 гаруй хүнийг шагналаа.	
41	Органик хүнсийг баталгаажуулах хамтын баталгаажуулалтын байгууллагыг орон нутагт байгуулж, бүртгүүлсэн байх	0		Сэлэнгэ аймагт 14, Төв аймагт 2 хамтын баталгаажуулалтын байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр аймгуудаас туршлага судлах	Хамтын баталгаажуулалтын байгууллага байгуулж, бүртгүүлсэн байна.	Органик хүнсний хэрэглээг дэмжих, хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх, сүлжээ бий болгох, нэр төрлийг нэмэгдүүлэх, баталгаажуулах боломжийн талаар Эс эф си эс ХХК-тай хамтасан сургалт зохион байгууллаа. Сургалтад төр, хувийн хэвшлийн байгууллагын 43 хүн хамрагдаж орон нутгийн органик бүтээгдэхүүнийг баталгаажуулалтад хамруулах талаар санал бодлоо солилцсноор “Органик хүнсийг баталгаажуулах хамтын баталгаажуулалтын байгууллага”-ыг орон нутагт байгуулах ажлын эхлэл тавигдлаа.	30
Хөнгөн үйлдвэрийн салбарын чиглэлээр							
42	Төрийн худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх ажлыг	ОНТ – 1,607.2 сая	Төрийн хуалдан авалтад дотоодын үйлдвэрийн нийлүүлэлт	Төрийн худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлт	Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийн түвшинг өмнөх	Дотоодын үйлдвэрлэл эрхлэгч иргэн ААНэгжээс аймгийн хэмжээнд мах, сүү гэх мэт 50 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүний 250 сая төгрөгийн худалдан авалт	100

	удирдан, зохион байгуулах		урьд оныхоос өссөн байна.	хангалтгүй байна.	оноос ахиулсан байна.	хийсэн. Өнөөгийн байдлаар ОНӨГ-аас 43 тендер шалгаруулалтыг зарлан зохион байгуулж 13 тендерт орон нутгийн аж ахуйн нэгж шалгарч 1,357,299,019 төгрөгний гэрээ байгуулсан нь орон нугийн аж ахуйн нэгжийн эзлэх хувь өмнөх оноос 51,8-иар өссөн.	
43	Арьс ширэн түүхий эдийн нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх	Хувийн хэвшил – 40,0 сая		Улсын хэмжээнд арьс шир боловсруулах үйлдвэрүүд хагас боловсруулах хүчин чадлын 33.8%, гүн боловсруулах хүчин чадлын 68.6%-ийг тус тус ашиглаж байна. Иймд нядалгааны үеийн гэмтлийг бууруулж арьс ширэн түүхий эдийн нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх шаардлагатай.	Арьс шир хуулах төхөөрөмжийг мал төхөөрөх цехэд нэвтрүүлсэн байна. Хоршоод, мал төхөөрөх цех, түүхий эдийн агуулахад ажиллаж буй ажилчдыг чадавхижуулах сургалтыг сум, аймгийн түвшинд мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна. Түүхий эдийн агуулахууд ХААБ-ээс агуулахын итгэмжлэл авсан байна. Түүхий эдийн агуулахууд таваар судлаач	ХХААХҮЯам, Unido олон улсын байгууллага, Арьс ширний холбоо, махны холбоотой хамтран мал, мах нийлүүлдэг газарт бод, бог малын арьсыг исгэхгүй хуулах үзүүлэх сургалтыг зохион байгуулж НҮБ-ын Аж үйлдвэр, хөгжлийн байгууллагын дэмжлэгтэйгээр “Малын арьс шир өвчиж, хуулах SFF төхөөрөмж”-ийг “Шувуутайн оргил” ХХК-ны мах төхөөрөх цехэд суурилууллаа. Дундговь аймгийн Гурвансайхан сумын Дэрсэнэ-Усны багийн малчин Д. Батбаатарынх Салхитын орд руу татсан 35 кВ-ын шугамнаас хүчдэл буулган дэд өртөө байгуулснаар дөрвөн өрх цахилгаан эрчим хүчээр хангагдаад зогсохгүй “Арьс нэхий боловсруулах үйлдвэр”-ийн тоног төхөөрөмж суурилуулан арьс нэхийг боловсруулж эхлээд байна.	30

					мэргэжлийн хүнийг ажиллуулж түүхий эдэд чанарын үнэлгээ, ангилах, зэрэглэх, үнэ тогтоох, тоо хэмжээг гаргах, хадгалалтын аргыг тодорхойлох, хянах үйл ажиллагаа явуулсан байна. Хоршоод, түүхий эд бэлтгэлийн төлөөлөгчид арьс ширэн түүхий эдийг тээвэрлэхдээ Түүхий эд бэлтгэл. Боловсруулаагүй арьс шир. MNS 0060:2013 стандартыг мөрдүүлсэн байна.		
44	Ноосон түүхий эдийн нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх, хонь хяргах төхөөрөмжийг нэвтрүүлж түүхий эдийн чанар, гарцыг дээшлүүлэх;	Төсөл хөтөлбөр-30,0 сая		Ноосны гарц, чанарыг сайжруулах хүрээнд хийгдсэн ажил хангалтгүй байна.	Хонь хяргах төхөөрөмжийг хоршоодод нэвтрүүлж ноосон түүхий эдийн чанар, гарцыг дээшлүүлсэн байна. ААНБ, хоршоодод хонь хяргах	ХХААХҮЯ, ХАА-н биржтэй хамтран Хэнтийн аймгийн Баян-Овоо сум, Баян-Өлгий аймгийн Ногоон нуур багийн 25 малчинд хонийг цахилгаан хайчаар хяргах, ноосыг ангилан ялгах 5 хоногийн сургалтыг зохион байгуулж цахилгаан хайчаар хонь хяргаснаар гарах үр ашгийн	70

					ажилчдыг чадавхижуулах сургалтыг сум, аймгийн түвшинд мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна.	талаархи мэдлэгийг олголоо. Сургагч багшаар МҮА-ны мэргэжилтэн Э.Уугандорж ажилласан. Манай аймгийн хувьд хаваржилт хүндэрч шороон шуурга олон удаагийн давтамжтай болсон, мөн хонь хяргах технологит хугацаанд ковидын хөл хорио тогтоогдсон зэрэг хүчин зүйлээс шалтгаалан цахилгаан хайчаар хонь хяргах ажил хийгдээгүй.	
45	Сав баглаа боодол” хөтөлбөрийн хүрээнд “Хөх сав, канистргүй аймаг, сум” хөдөлгөөн өрнүүлэх ажлыг эрчимжүүлэх, уламжлалт сав баглааны үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих, олон нийтийн оролцоотой хөх савны хор хөнөөлийг сурталчилах	Хувийн хэвшил 7,5 сая Говийн зэрэглээ төсөл – 7,5 сая	Зориулалтын сав хэрэглэдэг айл, өрхийн тоо өмнөх оноос өссөн байна.	Малчид пестицидийн цэнхэр сав, барилгын материал, замаскны савыг хүнсний зориулалтаар ашигласан тохиолдолд торгууль, шийтгэвэр ногдуулах, устгалыг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх ажил хангалтгүй, мэдээлэл сурталчилгаа муу байна.	“Хөх сав, канистргүй аймаг, сум” хөдөлгөөн өрнүүлсэн байна. Уламжлалт эко сав баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжиж, хэрэглээг нэмэгдүүлсэн байна. Химийн бодисын хуванцар савны хор хөнөөлийг иргэд, олон нийтэд сурталчилсан байна. 50 хүртэлх тооны малчин өрх зориулалтын бус савнаас	“Хөх сав, канистергүй аймаг, сум” аяны хүрээнд химийн бодис савлагдах зориулалт бүхий хуванцар савны хор хөнөөлийг иргэд олон нийтэд сурталчлах ажлыг 3 удаа зохион байгуулсны үр дүнд зориулалтын савны хэрэглээтэй айл өрхийн тоо 7200 буюу 50,2 хувь боллоо. Мөн Хулд суманд “Говийн зэрэглээ” төслөөс 15,0 сая төгрөгийн өртөг бүхий 1 иж бүрдэл нь модон торх, 35 литрийн бетон, ингэ саадаг бүслүүрээс бүрдсэн багцыг 50 малчин өрхөд нийлүүлжээ. Нийт зардлын 50 хувь 7,5 сая төгрөгийг малчин өрх гаргасан байна. Уламжлалт эко савны үйлдвэрлэл эрхлэгч ТЭББЭ	100

					татгалзсныг баталгаажуулж, тайлагнасан байна.	ХХК нь 6800 ширхэг хувин үйлдвэрлэн зах зээлд борлуулж нийт 546,0 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна.	
46	Аймаг, суманд дахин боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн тогтолцоог нэвтрүүлэх	0	Сургалтын тоо Хамрагдсан иргэдийн тоо	Орон нутгийн ААН, иргэд дахин боловсруулах үйлдвэрлэлийн талаар мэдлэг мэдээлэл дутагдалтай байна.	Дахин боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр иргэд, аж ахуйн нэгжүүдэд 2 удаагийн сургалт зохион байгуулна.	Аймгийн Засаг дарга Ц.Мөнхбатын санаачлагаар орон нутагтаа уламжлалт гар урлал, жижиг дунд үйлдвэрлэлийн дизайныг хөгжүүлэхэд ур чадвар, арга зүйн дэмжлэг, зөвлөгөө үзүүлэх, орон нутгийн онцлогтой Брэнд бүтээгдэхүүн төрүүлэх зорилгоор ШУТИС-ийн дизайн сургуулийн "НҮҮДЛИЙН УРЛАН" сургалтын багтай хамтарсан сургалтыг зохион байгуулж 7 сумын 20 үйлдвэрлэл эрхлэгч иргэн хамруулсан. Мөн СХСангаас түүхий эдийг дахин боловсруулан эцсийн бүтээгдэхүүн гаргах чиглэлээр зээл авсан 2 ААНэгжүүд төслийн дагуу шавь сургалтуудыг авсан.	100
Жижиг, дунд үйлдвэрийн салбарын чиглэлээр							
47	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх	ЗБДС- 90,0 сая	Эх үүсвэр өмнөх оноос нэмэгдсэн байна.	Орон нутгийн төсвийн санхүүжилт хангалтгүй байна.	Эх үүсвэрийг өмнөх оноос нэмэгдүүлэх арга хэмжээ авсан байна.	Улсын төсвийн хөрөнгөөс орон нутагт төсөв хуваарилагдаагүй. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан Ажлын байрыг дэмжих зээлээс Хангда ХХК 90,0 сая төгрөгийн санхүүжилт	70

						аван үйл ажиллагаагаа явуулж байна. 2 ажлын байр шинээр бий болсон. Зээлийн батлан даалтын санд хамрагдан барьцаа хөрөнгөний 30 хувийг гаргуулсан.	
48	Сум хөгжүүлэх сангийн зээлдэгчийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн сантай бүрэн нэгтгэх ажлыг зохион байгуулах, сангийн эргэн төлөлтийг сайжруулах	СХС-798,5 сая	Зээлийн програмд зээлдэгч нарын мэдээллийг бүрэн оруулсан байна.	Мэдээлэл нэгтгэх ажил хангалтгүй байна.	Зээлдэгчийн мэдээллийг ЗМС-д нэгтгэж, мэдээлэл солилцоог сайжруулсан байна.	Монгол банкны мэдээллийн санд 15 сумын нийт 446 иргэн, ААН-ийн мэдээллийг шивж оруулсан. 2021 онд Дэлгэрцогт, Сайнцагаан, Өндөршил, Баянжаргалан сумд 19 иргэн, ААНэгжид 482,0 сая төгрөгийн зээлийг олгож шинэ ажлын байр 35 бий болж 20 ажлын байр хадгалагдсан.	100
49	"Загвар хоршоо" байгуулахад дэмжлэг үзүүлэх, хоршооны туршлага дэлгэрүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Хувийн хэвшил – 28,8 сая	Загвар хоршоог 1-р нэмэгдүүлсэн байна.	-	Загвар хоршоонд дэмжлэг үзүүлсэн, туршлага солилцсон байна.	Гурвансайхан сумын Давших зам хоршоо нь 2021 онд 83 тн хонины ноос бэлтгэн "Могол ноос" ХХК-д нийлүүлж, 2020 оны хоршооны ашиг 20,3 сая төгрөгийг нийт 245 гишүүнд хуваарилан олгосон бол хаврын шуурганд өртсөн хоршооны гишүүн малчин өрхдөө 8,5 сая төгрөгийн шатахууны дэмжлэг үзүүлж, Жижиг дунд үйлдвэрийн газраас зохион байгуулсан дотоодын туршлага судлах, үзүүлэх сургалтад 1 гишүүнийг хамруулжээ.	100

50	"Нэг сум-Нэг хоршоо" аяныг зохион байгуулах	СХС – 25,0 сая	Шинээр байгуулагдсан хоршооны тоо Хоршоонд олгосон дэмжлэгийн дүн	Хоршооллох хөдөлгөөнийг эрчимжүүлэх ажил хангалтгүй хийгдэж байна.	Аяныг зохион байгуулж үр дүн гаргасан байна.	Нэг сум – Нэг хоршоо аяны хүрээнд Хулд, Сайнцагаан суманд ХАА-н бүтээгдэхүүн худалдан, борлуулах чиглэлээр 3 хоршоо шинээр байгуулагдсан. Дэлгэрцогт сумын “Ширээс” хоршоонд Сум хөгжлийн сангаас арьс, шир боловсруулах цехийн үйл ажиллагааг дэмжиж 25,0 сая төгрөгийн зээл олгосноор шинээр 2 иргэнийг ажлын байраар ханган 4 ажлын байр хадгалагдсан. Зээлийн үр дүнд 3-4 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 10,0 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллажээ. Мөн Өлзийт сумын хоршоо эрхлэх хүсэлтэй 3 иргэнд “Хоршооны тухай хууль” болон хоршоо байгуулахтай холбоотой бусад мэдээллийн талаар арга зүйн зөвлөгөө мэдээлэл өглөө.	100
51	Явуулын ахуйн үйлчилгээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	Аймгийн төсөв	Явуулын ахуйн үйлчилгээний нэр, төрөл Үйлчлүүлсэн иргэдийн тоо	Иргэдэд хүргэж байгаа нийтийн ахуйн үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ цөөн байна.	Нийтийн ахуйн үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээг урьд оноос нэмэгдүүлсэн байна.	Явуулын ахуйн үйлчилгээ шаардлагатай сумдын судалгааг авсны дагуу 12 дугаар сарын 3-ны өдөр Өлзийт суманд 6 төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 90 гаруй иргэнд хүргэж үйлчилсэн байна.	100
52	Аймгийн хэмжээнд ахуйн үйлчилгээний “Шилдэг төв” шалгаруулах арга	ЖДҮГ, ОНЗД	“Шилдэг төв” шалгаруулсан байна.	-	Арга хэмжээг зохион байгуулж шилдэг төвийг	Шалгаруулах удирдамжийг цахимаар болон албан бичгээр хүргүүлсэн. Шалгаруулалтад материалаа ирүүлсэн 10 гаруй	100

	хэмжээ зохион байгуулах				шалгаруулсан байна.	газраас ажлын хэсгийн гишүүдийн саналаар “Уран брэнд” оёдлын үйлдвэр, “Best” үсчин гоо сайхны салон, “Содон” гоо сайхны салоныг тус тус шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнав.	
53	Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний чанар стандартыг хангуулах, тохирлын баталгаажуулалт хийлгэх, ач холбогдлыг сурталчлах, мэдээлэх чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах	0	Тохирлын баталгаажуулалт хийсэн байна.	Хариуцсан мэргэжилтэнийг аудиторoor бэлдсэн.	Орон нутгийн бүтээгдэхүүн үйлчилгээнд тохирлын баталгаажуулалт хийсэн байна.	Стандарт хэмжил зүйн газартай хамтран 21 газарт стандартын зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж 5 газрын тохирлын үнэлгээний баталгаажуулалтын явцад орон тооны бус зөвлөлийн гишүүнээр ажиллалаа.	100
54	“Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” аян зохион байгуулах	УТ – 2,0 сая төгрөг	Брэнд бүтээгдэхүүний цахим сэтгүүл гарсан байна.	Брэнд бүтээгдэхүүнийг бий болгох чиглэлээр ихэвчлэн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж байгаа нь хангалтгүй бнa.	“Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” аяны хүрээнд орон нутгийн брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлж, тодорхой бүтээгдэхүүнийг хөгжүүлсэн байна.	Нэг суурин – Нэг бүтээгдэхүүн аяныг 11 дүгээр сарын 20-ноос 12 дугаар сарын 20-ны өдрийн хугацаанд өрнүүлэн ажиллаж байна. Уг ажлын хүрээнд Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бэлгийн багц бэлтгэх, Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, маркетинг, менежментийн сургалт зохион байгуулах,	100

						“Дундговь нутгийн брэнд” бүтээгдэхүүний лого бүтээх уралдаан зарлаж, дүгнэх, Аймагт үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварын судалгаа хийх зэрэг ажлуудыг төлөвлөлөө. 2021 оныг “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгон зарласан. Уг ажлын хүрээнд 15 сумын үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэгчдийн мэдээллийг багтаасан цахим сэтгүүлийг http://dundgovi.gov.mn/ сайтад байршууллаа. Улаанбаатар хотод болсон Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаанд оролцсон бүтээгдэхүүнээс “Тэмээний ноосон хөнжил”, “Даршилсан хөмүүл” шалгарч орон нутгийн брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүллээ.	
55	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд шаардлагатай мэдээ, мэдээллийн нэгдсэн бааз бүрдүүлэх, судалгаа хийх, түгээх, баяжуулж, шинэчилж ажиллах	0	Мэдээллийн бааз бүрдүүлсэн байна.	Мэдээллийн нэгдсэн бааз бүрдээгүй.	Судалгаа хийгдэж, мэдээллийн бааз бүрдүүлсэн байна.	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, ахуй үйлчилгээний салбарын мэдээллийг батлагдсан маягтын дагуу авч нэгтгэн Жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүлснээр 315 бизнес эрхлэгчийн мэдээллийн санг бий болголоо.	100
56	Хоршооны салбарын 100	0		Бүтээлч ажлын төлөвлөгөө	Бүтээлч ажлын төлөвлөгөө гаргаж	Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Хоршоонд	100

	жилийн ой хүрээнд бүтээлч ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах			гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	суурилсан ХАА-н тогтвортой хөгжил төсөл"-тэй хамтран дотоодын туршлага судлах, үзүүлэх сургалтад ЖДҮ хариуцсан мэргэжилтэн, хоршоодын төлөөлөл 6 хүн хамрагдаж хоршооны тухай хууль бусад холбогдох мэдээллийг сонссон. Уг арга хэмжээний үеэр "Сүүн далайн оргил" сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах хоршоо, ХАА Биржийн "Ложистикийн төв", "Цэвэр хөрсний шим" дундын хоршооны үйл ажиллагаатай тус тус танилцаж, харилцан туршлага солилцсон. Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь.	
57	Ахуйн үйлчилгээний салбарын 90 жилийн ойн хүрээнд бүтээлч ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах			Бүтээлч ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	Бүтээлч ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	Хоршоо, Ахуйн үйлчилгээний салбарын үүсч хөгжсөний түүхт ойг угтан сум орон нутагт явуулын ахуй үйлчилгээг зохион байгуулах, үсчдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, худалдааны байгууллага, ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн дунд гар бөмбөгийн тэмцээнийг тус тус зохион байгуулсан ба тухайн салбарт амжилттай ажиллаж байгаа 10 гаруй хүнийг салбарын шагналд тодорхойлон	70

						шийдвэрлүүлээ. Мөн ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж мэргэжлийн холбоодыг шинээр байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд МСҮТ-ийн дэргэд оёдолчин мэргэжлийн зөвлөлийг байгуулж, зөвлөлийн дүрэм, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталлаа. Мөн Мерит төсөлтэй хамтран 12 дугаар сарын 15-ны өдөр мэргэжлийн холбоодыг шинээр байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд оёдолчдод сургалтыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.	
Малын удмын сангийн чиглэлээр							
58	Аймгийн төвд байгаа Малын удмын сангийн үндэсний төвийн цөм сүргийн нэгжийн конторын барилга, газар, агуулахын ашиглалтыг сайжруулах чиглэлээр орон нутгийн захиргааны байгууллагатай зөвшилцөж цаашид			Цөм сүргийн нэгжийн конторын барилга, газар, агуулах ашиглалтгүй байгаа.	Цөм сүргийн нэгжийн конторын барилга, газар, агуулахын эзэмшил, ашиглалт тодорхой болсон байна.	Малын удмын үндэсний сангийн харьяа барилга, байгууламжийг Орон нутгийн өмчит газраас Төрийн өмчит газарт шилжүүлэх хүсэлтийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй байна. Цөм сүргийн нэгжийн конторын барилга, байгууламжийг ХХААГ-ын хяналтад байлгаж байна.	70

	үр дүнтэй ашиглах асуудлыг шийдвэрлэх,						
59	Цэвэр үүлдрийн болон гойд ашиг шимт малын үрээр малчид, аж ахуйн нэгжийн малд зохиомол хээлтүүлэг хийж, малын үржлийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх,			Гойд ашиг шимт хээлтүүлэгч малын үрээр зохиомол хээлтүүлэг хийж байгаагүй.	Зохиомол хээлтүүлэгт хамрагдсан малын тоо нэмэгдэж, малчдын малын чанар сайжирсан байна.	Зохиомол хээлтүүлгийн ажлыг энэ оноос эхлэн аймгийн хэмжээнд хийж байгаа бөгөөд нутгийн 400 эм хонинд хийсэн. Хээлтүүлгийн ажил 85 хувьтай байна. Нутгийн монгол үүлдрийн 17-н үхэрт Сэлэнгэ үүлдрийн гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн. Өнгөрсөн онд “Ялалт баян амьдрал” хоршоотой хамтран нутгийн 1000 монгол хонинд махны чиглэлийн суфолок үүлдрийн хуцнаас үр авч зохиомол хээлтүүлэг хийж төл хүлээн авалт 85 хувийн үр дүнтэй байлаа.	100
60	Малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалтад 2 мэргэжилтэнг хамруулан мэргэжлийн чадамж олгох,			Өмнөх онд чадамжийн сургалтанд хүн хамрагдаагүй.	Аймаг, сум орон нутгийн мэргэжилтнүүд чадваржиж биотехнологийн дэвшилтэт аргыг ашиглан малын чанарыг богино хугацаанд сайжруулах нөхцөл бүрдэнэ.	Луус, Дэрэн сумдын мал аж ахуйн болон мал үржлийн аж ахуй нэгжийн мэргэжилтэн, ХААИС-ийн 1 оюутанг Сайнцагаан сумын хонины зохиомол хээлтүүлгийн ажилд сургаж, мэргэшүүлсэн.	100
Судалгаа хөгжлийн төвийн чиглэлээр							
65	ХХААХҮ-ийн салбарын Судалгаа хөгжлийн төв УТҮГ-	-	-	Засгийн газрын 2020 оны 93 дугаар	ХХААХҮ-ийн салбарын Судалгаа	ХХААХҮЯ, Судалгаа хөгжлийн төв, UNIDO төсөл хамтран Дундговь аймагт малын арьс,	100

	аас хэрэгжүүлэх судалгаа, туршилтын ажил, түүхий эд бүтээгдэхүүний мөрдөн мөшгөх тогтолцоо, технологи нэвтрүүлэх, дамжуулах, зөвлөх үйлчилгээний талаархи сургалтад дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах			тогтоолоор ХХААХҮ-ийн салбарын Судалгаа хөгжлийн төв УТҮГ-ыг байгуулсан.	хөгжлийн төвтэй хамтран ажиллаж судалгаа, туршилт хийгдсэн үр дүнг тооцсон байна.	шир өвчиж хуулах 8 сая төгрөгний өртөг бүхий SFF төхөөрөмжийг “Шувуутайн Оргил” мал төхөөрөх цехэд суурилуулсан. Энэ нь түүхий эдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, малыг үйлдвэрлэлийн орчинд төхөөрч, хүнсний эрүүл аюулгүй байдлыг сайжруулах зэрэг давуу талтай. Бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бэлчээрийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх ажлын хүрээнд НҮБ-ын ХААБ-ын хөрөнгө санхүүжилтийн дэмжлэгтэйгээр ХААИС-ийн Агроэкологийн сургууль, холбогдох мэргэжлийн 12 эрдэмтэн судлаачдаас бүрдсэн судалгаа шинжилгээний ажлын баг “Уур амьсгалд ухаалаг хөдөө аж ахуй” судалгааны ажлыг 5 сарын хугацаанд хийж үр дүн цаашид авч хэрэгжүүлэх ажлын зөвлөмж, сум тус бүрээр гарах төлөвлөгөөний эцсийн хэлэлцүүлгийг 11 сарын 30-ны өдөр Улаанбаатар хотноо хийлээ.	
Жендерийн чиглэлээр							
66	“Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жендерийн	-	ХХААХҮ-ийн салбарын Судалгаа хөгжлийн	Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн	Хүнтэй холбоотой бүх судалгаа, тайлан, мэдээнд хүйсийн	Байгууллагын дотоод журамд Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар 6 заалтыг тусган хэрэгжүүлж байна.	100

талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх хүрээнд хүнтэй холбоотой бүх судалгаа, тайлан, мэдээнд хүйсийн ангилалыг тусгаж ирүүлсэн байх		төвтэй хамтран ажиллаж судалгаа, туршилт хийгдсэн үр дүнг тооцсон байна.	хүрээнд ХХААХҮ-ийн Сайдын 2018.05.17-ны өдрийн А-94 тоот тушаалаар ХХААХҮ-ийн салбарт жендерийн талаар баримтлах бодлого батлагдсан. Бодлогыг хэрэгжүүлэх ажил 2020 онд хангалтгүй хэрэгжсэн.	ангилалыг тусгаж харуулсан байна	Жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт сэдэвт анхан ба ахисан түвшний 2 шатлалт онлайн сургалтанд нийт 12 албан хаагч хамрагдан сертификат авсан. "Би жендерийн хэвшмэл ойлголтын эсрэг байна" аянд байгууллагаараа нэгдлээ. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт нийт 40 албан хаагч ажиллаж байгаагаас эмэгтэй-21 буюу 52,5 %, эрэгтэй 19 буюу 47.5 % эзэлж байна. Энэ онд боловсон хүчний хүрэлцээ өмнөх оноос 7,5 хувиар нэмэгдсэн.	
100 хувь -46, 70 хувь-12, 30 хувь-3, 0 хувь -1 ХЯНАСАН:						89,1

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА

Б.МӨНХЖАРГАЛ

(албан тушаал)

(гарын үсэг)

(гарын үсгийн тайлал)

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ДАХШУ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

О.ГАНЦЭЦЭГ

(албан тушаал)

(гарын үсэг)

(гарын үсгийн тайлал)